

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАЛ

1. Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь “**Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа**”-ны мэдээлэл цуглуулах ажилд гүйцэтгэгч сонгон шалгаруулах тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэ зөвлөх үйлчилгээний зорилго нь 2019 оны хөдөлмөрийн зах зээлийн ажиллах хүчний эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулалтыг захиалагчаас боловсруулсан судалгааны арга зүйн дагуу хийж, мэдээллийн бааз үүсгэн, гэрээний хугацаанд хүлээлгэн өгөх болно.

3. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- ✓ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй;
- ✓ Судалгаа, шинжилгээний ажлын чиглэлээр 3 – аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай;
- ✓ Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны асуудлын хүрээнд бүс нутаг, улсын хэмжээнд мэдээлэл цуглуулалт гүйцэтгэж, судалгааны дүн шинжилгээ хийсэн туршлагатай;
- ✓ Мэдээлэл цуглуулалт хийж гүйцэтгэх хангалттай туршлагатай хүний нөөцтэй;
- ✓ Судалгааны багийн ахлах, голлох мэргэжилтнүүд нь хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн асуудлын талаар мэдлэг, туршлагатай, эдийн засаг, нийгмийн ухааны чиглэлээр мэргэшсэн байх. */Нотлох бичиг баримтыг ирүүлэх/*

4. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (нийтлэл, ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ.

5. Сонирхсон этгээд мэдүүлгээ 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс 04 дүгээр сарын 11-ны өдрийн 09.00 цагаас өмнө дор дурдсан хаягаар ирүүлнэ үү.

**Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо,  
Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний  
ерөнхий газрын байр, 5 дугаар давхар,  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт  
Утас 77121286**